



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/48

Мөрөн сум

"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил"
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оныг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил" болгон зарласугай.
2. Нэрлэсэн жилийн ажлыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, нэгдсэн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Нэрлэсэн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг төсвийн тодотголоор болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр шийдвэрлэж, нэгдсэн удирдлагаар ханган үр дүнтэй зохион байгуулах, жилийн ажлын үр дүнг 2022 оны 12-р сард багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (П.Ариунбат)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 09-ний өдрийн
А/48 дүгээр захирамжийн хавсралт

**"ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЖИЛ"-ИЙН АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Аймгийн Политехник коллежийн захирал

Мөрөн сумын Засаг даргын орлогч

Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл аймаг дахь салбарын
дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, үйл
ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн

-----oOo-----